

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2023 ОНЫ
БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАН

2023.12.15

№	Нээлттэй мэдээлэл	Хэрэгжилт	Хувь
НЭГ.ЧИГ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ			
1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	<p>Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн байгууллагын эрхэм зорилго, зорилт, үйл ажиллагааны стратегийг төлөвлөгөө зэргийг боловсруулан ажиллаж байна.</p> <p>1. Байгууллагын эрхэм зорилго</p> <p>Эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг өндөр мэдлэг чадвар, дэвшилтэт технологид тулгуурлан үзүүлж, үйлчлүүлэгчийн амьдралын чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.</p> <p>2. Үйл ажиллагааны стратегийн зорилго</p> <p>Эрүүл мэндийн цогц, шуурхай, чанартай үйлчилгээг өндөр мэдлэг, чадвар бүхий эмч мэргэжилтнүүд дэвшилтэт технологид тулгуурлан үзүүлж, үйлчлүүлэгчийн амьдралын чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Үйл ажиллагааны стратегийн зорилт:</p> <p>1.Эмнэлгийн брэнд үйлчилгээ болох Цөмийн оношилгооны төв, төрөлжсөн Дурангийн мэс заслын төв, Судсан дотуурх оношилгоог тус тус хөгжүүлнэ.</p>	100%

		<p>2.Анагаах ухааны шинэ дэвшилтэт техник, технологи, оношилгоо, эмчилгээ, Роботик мэс засал нэвтрүүлэх, нутагшуулах.</p> <p>3.УХТЭ-ийн дэргэдэх Сувилахуйн Сургуулийг байгуулж, дотооддоо сувилагч хүний нөөцийг бэлтгэнэ.</p> <p>4.Олон улсын магадлан итгэмжлүүлэгч байгууллагаар итгэмжлүүлнэ. (JCI)</p> <p>5.Гадаадын иргэдийг хүлээн авч чанартай тусламж, үйлчилгээ үзүүлнэ.</p> <p>3. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ ба үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> ● Цөмийн оношилгоо эмчилгээний төв /ЦОЭТ/ нь циклотронд суурилсан цацраг идэвхт эм үйлдвэрлэлт, молекул дүрсийн оношилгоо болох ПЭТ/КТ технологийг Монгол улсад анх удаа нэвтрүүлэн улсын хэмжээнд тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. ● 2023 онд остеоартриттай хүнд өвдөгний үений эмгэг судасжилт бөглөх мэс ажилбарыг нэвтрүүлж одоогоор 35 хүнд мэс ажилбарыг амжилттай хийж 1,3,6 сар,1 жил гэсэн давтамжаар хяналт хийн ажиллаж байна. ● 2023-1 сараас 11 сарын 17-ны хооронд өвдөгний үе солих 185, түнхний үе бүтэн солих 18, түнхний үе хагас солих 9 хагалгаа, өвдөгний үений дурангийн 21 хагалгаа хийгдсэн байна. ● Мэдрэлийн мэс заслын тасаг болон ангиографийн тасаг хамтран нурууны нугаламын үсэрхийлсэн хавдартай өвчтөнд эмч нарын хамтарсан үзлэг, зөвлөгөө хийж байна. Одоогоор нурууны нугаламын хавдарыг бөглөх эмчилгээг хийлгэх тохиолдол гараагүй байна. Элэгний анхдагч хавдараас бүсэлхий нуруунд үсэрхийлсэн тохиолдлыг мэдрэлийн мэс заслын тасаг болон дүрс оношилгооны тасагтай хамтран компьютер томографийн хяналтан дор хөлдөөх эмчилгээг шинээр нэвтрүүлэн ажиллаж байна. ● 2023 оны 1-р улиралд Судалгааг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07-р сарын 01 өдрийн А/346 тоот тушаал гарсантай холбоотойгоор эмнэлгийн байгууллага нь хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээг байгууллагын онцлогт тааруулан боловсруулан гаргах болсонтой холбоотойгоор Улсын хоёрдугаар төв эмнэлгээс боловсруулсан асуумжийн дагуу судалгаа 	
--	--	--	--

		<p>авсан. Амбулаторийн ерөнхий сэтгэл ханамжийн хувь 90.2%. Хэвтэн эмчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамжийн хувь 91.7% байна. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр үйл ажиллагаа сайжруулах төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Компьютер томографийн хяналтан дор уушигны үсэрхийлсэн болон анхдагч хавдраас эдийн шинжилгээ авах, хавдарыг түлэх зэрэг мэс ажилбарууд амжилттай хийгдэж байна. • Нийгмийн эрүүл мэндийн нийт хүн амд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан. ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болох А/559 дүгээр тушаал /Эрүүл, чийрэг эр хүн/, А/760 дугаар тушаалыг /Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд/ хэрэгжүүлэн ажилласан. Эрүүл, чийрэг эр хүн арга хэмжээний хүрээнд 2023 онд 3 зорилтын хүрээнд 11 үйл ажиллагааг төлөвлөн амжилттай хэрэгжүүлсэн. • Тархины MRI спектроскопи, перфузи,трактографи зэрэг шинжилгээг шинээр нэвтрүүлэн хийж байна. • Төгсөлтийн дараах сургалтын загвар эмнэлэг болох зорилтын хүрээнд Сувилахуйн сургагч багш бэлтгэх сургалтыг байгууллага дээрээ авсан 3 дахь байгууллага болсон. Сувилахуйн сургагч багш бэлтгэх сургалтанд 22 сувилагч, 2 тусгай мэргэжилтэн 24 сургагч багш бэлтгэгдсэн. Төгсөлтийн дараах сургалтыг 5 чиглэлээр нэмэгдүүлэх бэлтгэл ажлуудыг ЭМС-ын 337 тоот тушаалын дагуу хийж гүйцэтгэсэн . 2024 оны 3 сараас сургалтыг 5 чиглэлээр нэмэгдүүлэх болно. 	
1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	<p>Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ssch.gov.mn домэйн хаягтай цахим хуудасны Танилцуулга хэсэгт бүтэц зохион байгуулалт, хаяг байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг зэрэг мэдээллүүд нийтлэгдсэн. https://ssch.gov.mn/articles/show/alban-haagchdyn-medeelel/mn</p> <p>Нийгмийн сүлжээний хаяг нь: 34,000 like, 42,000 дагагчтай https://www.facebook.com/ssch.gov.mn</p>	100%
1.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ,	<ul style="list-style-type: none"> • Эмнэлгийн захирлын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар 2023 оны батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх 	50%

	үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж	<p>зорилгоор ажлын хэсэг байгуулан ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> • Эмнэлгийн захирлын "Эмнэлгийн үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах тухай" 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/128 дугаар тушаалаар 7 бүлэг, 24 үүрэг даалгаврыг мөрдлөг болгон ажиллахыг нийт эмч, сувилагч, мэргэжилтэн, төв, албадын дарга, тасгийн эрхлэгч, дэд захирлууд нарт даалгасан. • Эс Жи Эм Ди ХХК явцын аудитын хүрээнд шалгасны дагуу 15 асуудлын бүртгэл ирүүлсний үндсэн дээр манай байгууллага 2022, 2023 оны биелэлтийг 2023 оны 11-р сарын 23-нд илгээсэн. 	
1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	Дотоод аудит, хяналт шалгалтын ажлын 2023 оны төлөвлөгөөнд хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх ажлыг тусгаж, ажлын хэсэг томилон удирдамж, төлөвлөгөөг батлуулан ажиллахаар төлөвлөсөн. Үндэсний аудит газар, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, ЭсЖиЭмДи-Аудит ХХК-тай гурвалсан гэрээгээр 2023 оны Санхүүгийн тайлангийн аудитын ажил 2023 оны 10 дугаар сарын 31-нээс 2024 оны 02 дугаар сарын 10-ны хооронд үргэлжилнэ.	100%
1.5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	<ul style="list-style-type: none"> • Цөмийн оношилгоо эмчилгээний төв /ЦОЭТ/ нь циклотронд суурилсан цацраг идэвхт эм үйлдвэрлэлт, молекул дүрсийн оношилгоо болох ПЭТ/КТ технологийг Монгол улсад анх удаа нэвтрүүлэн улсын хэмжээнд тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. • Эмнэлгийн Аксис карте программыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн систем болох WHONET программтай холбож 2 системд мэдээлэл ижил ордог болсон байна. Эмнэлгийн мэдээллийн системээс эмгэг төөрөгч үүсгэгч илэрсэн шинжилгээний хариуг WHONet программ руу илгээдэг болсон. • NaF /фторт натри/ эмийг Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгүүлж Эмийн бүртгэлийн L20230914VH08589 дугаартай тарилгын уусмалын 0023243 бүртгэлийн гэрчилгээ авч ЭМЯ-ны Licemed цахим хуудаст байршуулсан. Эмнэлзүйн практикт 12 дугаар сарын хагасаас нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. 	100%

1.6	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт	<ul style="list-style-type: none"> • 1995-2021 онд батлагдсан хүчин төгөлдөр 43 хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 28 тогтоол, Эрүүл мэндийн сайд болон ТЕГ-ын дэд дарга, Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, генералтай хамтарсан тушаал, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2002 оны 122-р тушаал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/94, А/193-р тушаал, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2019 оны А/142, А/47-р тушаал, Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 116/А565-р тушаал, Эрүүл мэндийн сайд, ХХААХҮС-ын 2022 оны хамтарсан А/255 А/137 дугаар тушаал, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 49/118 дугаар тушаал зэрэг хамтарсан 7 тушаал, Эрүүл мэндийн сайдын 127 тушаал, холбогдох дүрэм, журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. • Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн актыг байгууллагын албан ёсны сайтад ил тод нээлттэйгээр байршуулсан. https://ssch.gov.mn/documents/huul-togtoomzh-zasgijn-gazryn-shijdver-busad-erh-z-jn-akt/mn?sort=date&dir=desc&p=10 	100%
1.7	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг	Улсын хоёрдугаар төв эмнэлгийн албан тушаалтнуудын мэдээллийг цахим хуудсанд https://ssch.gov.mn/articles/show/alban-haagchdyn-medeelel/mn -д байршуулсан.	100%
1.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ	Өргөдөл гомдол, санал хүсэлтийг 70150206, 70150205 утсаар, эмнэлгийн цахим веб хуудсаар (ssch.gov.mn), эмнэлгийн мэйл хаягаар (info@ssch.gov.mn) хүлээн авдаг. Түүнчлэн эмнэлгийн амбулаторийн хэсгүүдэд нийт 12 ширхэг санал хүсэлтийн хайрцаг байршуулсан. Үндэсний оношилгоо эмчилгээний төвийн 1 давхар, төв байрны 1 давхарт тус тус талархлын самбар ажиллуулдаг. Мөн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанд иргэдийн санал хүсэлт, гомдлыг ажлын цагаар тогтмол хүлээн авдаг. Өргөдөл	100%

		<p>гомдол, санал хүсэлтийг хүлээн авах утас, цахим хаягыг мэдээллийн самбаруудад ил тод харагдахаар байршуулсан.</p> <p>2023 оны жилийн эцсийн байдлаар Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанд нийт 152 өргөдөл гомдол, санал хүсэлт бүртгэгдсэн байна. Үүнээс Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой-36 буюу 23.6%, Эмч, ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа, хандлагатай холбоотой-16 буюу 10.5%, Эмчилгээний төлбөр, дэмжлэг хүсэхтэй холбоотой-66 буюу 43.4%, Улирал, цаг үеийн шинжтэй зонхилж багаа асуудал-0, Бусад-34 буюу 22.3% байна.</p> <p>Нийт ирсэн өргөдөл гомдлын бичгээр-62, цахим хэлбэрээр-1, утсаар хандсан-6, биечлэн уулзсан-14, 1111 төв-69 байна. Шийдвэрлэлт 100%.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 сарын 25-ны өдрийн А/50 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуух хүснэгтээр улирал бүр Эрүүл мэндийн яам руу тайлангаа илгээсэн.</p>	
1.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/279 тоот тушаалын дагуу албаны нууцын жагсаалт, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн эрүүл мэндийн мэдээлэлд хамаарахгүй хэсгийг ЭМХТ-д тогтмол гаргаж өгч, эмнэлгийн цахим хуудсаар ил тод байршуулдаг.	100%
1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	Олон нийтийн арга хэмжээ бүх төрлийн нээлттэй хөтөлбөрийг тухай бүрт нь эмнэлгийн цахим хуудсаар болон албан ёсны фейсбүүк пейж хуудсаар дамжуулан мэдээллэж байна.	100%
Хэсгийн дундаж хувь 95%			
ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ			
2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	<ul style="list-style-type: none"> • https://info.shilendans.gov.mn/login “Шилэн данс”-д байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр тайлагнасан. 	100%

		<ul style="list-style-type: none"> • Эмнэлгийн ЦАХИМ хуудасны http://ssch.gov.mn/ “АЖЛЫН БАЙРНЫ ЗАР болон эмнэлгийн албан ёсны фейсбүүк фейжд 2023 оны 12 дугаар сарын 13-ны байдлаар нийт 54 ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг давхардсан тоогоор 139 удаа ил тодоор байршуулсан. 2023 оны 12 дугаар сарын 13-ны байдлаар нийт 143 ажилтныг сонгон шалгаруулж шинээр ажилд авсан. Үүнд: 33 эмч, 55 сувилагч, туслах сувилагч, 24 үйлчлэгч, 31 бусад ажилтнууд байна. • 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Этүгэн их сургууль, 04 дүгээр сарын 21-ний өдөр АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн төгсөх дамжааны оюутнуудтай ажил олгогчдын нэгдсэн уулзалт арга хэмжээнд оролцож шинэ төгсөх сувилагч нарт эмнэлгийн давуу тал, хөгжих бололцоо зэргээр танилцуулга хийж, сувилагчаар ажиллах урилга гардуулсан. • 2023 оны 04 дүгээр сарын 27-ний өдөр Дархан-уул аймгийн анагаах ухааны сургуулийн ажил олгогч, төгсөгчдийн уулзалтанд байгууллагаа сурталчилах, сувилахуйн хүний нөөцийн бүрдүүлэлт хийх зорилготой оролцож бакалаврын 10, дипломын 4 оюутанд ажлын байрны батламж гардуулсан. 	
2.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	<ul style="list-style-type: none"> • Эмнэлгийн ерөнхий захирлын 2023 оны 03 дугаар сарын А/31 дүгээр тушаалаар "Эрүүл мэндийн ажилтан сонгон шалгаруулж, ажилд авах журам" шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна. Журмыг байгууллагын албан ёсны сайтад ил тод нээлттэйгээр байршуулсан. https://ssch.gov.mn/documents/azhlyn-bairny-talaarh-medeelel/mn?sort=date&dir=desc&p=25 • 2023 оны 12 дугаар сарын 13-ны байдлаар нийт 143 ажилтныг нээлттэй сонгон шалгаруулж шинээр ажилд авсан. Үүнд: 33 эмч, 55 сувилагч, туслах сувилагч, 24 үйлчлэгч, 31 бусад ажилтнууд байна. 	100%
2.3	Төрийн албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм	<ul style="list-style-type: none"> • Эмнэлгийн ажилтнуудын харилцаа, хандлагыг сайжруулах ажлын хүрээнд харилцаа хандлагатай холбоотой гомдлын мэдээллийг 7 хоног бүрийн Мягмар гарагийн хариуцлагатаны ярианд мэдээлж, дахин давтагдахаас сэргийлж ажилладаг. УХТЭ-ийн Сувилахуйн алба ЭМЭЗСХороо хамтран дараах ёс зүйн сургалтыг явуулсан. Амьдралд суурилж суралцахуй ТББ-д УХТЭ -ийн Сувилахуйн албаны (Ёс зүйн салбар хороо)-ны зүгээс 	80%

		<p>“Мэргэжилтэний ёс зүй-Харилцааны үр чадвар 1 багц цагийн сургалтыг УХТЭ-ийн эмч, сувилагч, эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтэн, ажилтануудад авах хүсэлт илгээсний дагуу тасралтгүй хөгжүүлэх нэн чухал асуудал болж буй эмнэлгийн мэргэжилтний Ёс зүй-Харилцаа хандлагын сургалтыг 2023 оны 02 дүгээр сарын 14-ний 14.00 цагт ҮОЭТ-ийн хурлын танхимд АШУҮИС-ийн БАС-ийн тэнхимийн багш С.Наранчимэг /АУ-ны доктор, профессор/, С.Нармандах /докторант/ нартай хамтран зохион байгуулж нийт 124 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан. Сургалтын үр дүнд эмч, сувилагч, эмнэлгийн ажилтууд биеэ авч яваа байдал, өөрийн бодол, биеийн хэлэмж, үгийн сонгол, дууны өнгөөс сэтгэлээсээ хандаж буй эсэхэд анхаарах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжид хэрхэн яаж хүрэх зэргээр дадлага онол хосолсон сургалт боллоо.</p> <ul style="list-style-type: none"> ● Эмнэлгийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд болон ажилтнуудад “Эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээ ба ажлын бүтээмж” сэдэвт 2 багц цагийн сургалтын удирдамжийг Эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн хяналтын хорооны дарга, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөр батлуулан эмч, эм зүйч нарт 2023 оны 11 дүгээр сарын 10-нд зохион байгуулж 194 эмч, эм зүйч нар хамрагдсан. ● “Байгууллагын соёл”, Эмнэлгийн ажилтны харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээ ба ажлын бүтээмж” сэдэвт 2 багц цагийн сургалтын сувилагч, дэмжих үйлчилгээний ажилтнуудад 2023 оны 11 дүгээр сарын 23-нд 150 сувилагч, ажилтнууд хамрагдсан. ● Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны гишүүдийн нээлттэй сонгон шалгаруулалтыг эмнэлгийн албан ёсны сайт болон фейсбүүк пейжд 2 удаа байршуулсан боловч сонгон шалгаруулалтанд материал ирээгүй. ● Үйлчлүүлэгчээс нэр бүхий 3 эмчид ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой гаргасан гомдлыг хэлэлцэн шийдвэрлэж, улирлын үр дүнгийн урамшууллыг тус тус 20% хассан. ● Эмнэлгийн албан ёсны цахим хуудасны (www.ssч.gov.mn) “Ил тод байдал” хэсгийн “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо” хэсэгтэй. https://ssч.gov.mn/about-us/show/yos-z-jn-horoony-2022-ony-t-l-vl-g/mn?sort=date&dir=desc&p=25 	
--	--	--	--

2.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	Эмнэлгийн албан ёсны цахим хуудасны (www.ssch.gov.mn) "Ил тод байдал" хэсгийн "Хүний нөөцийн ил тод байдал хэсэгт Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж /хуульчилсан акт/ дүрэм, журам, заавар жагсаалт, байгууллагын ил тод байдлын тайланг байршуулсан.	80%
2.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	Эмнэлгийн албан ёсны цахим хуудасны (www.ssch.gov.mn) "Ил тод байдал" хэсгийн "Үйл ажиллагааны ил тод байдал" хэсэгт "Эмнэлгийн даргын тушаал"-д 2016 оноос 2022 оны эмнэлгийн удирдлагын тушаалын жагсаалт, 2022 оны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлууд, түүний шийдвэрүүдийг байршуулсан.	90%
2.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоолоор тус тус батлагдсан "Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам"-ын дагуу Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу алба, тасгийн хамт олноор ил тодоор үнэлүүлдэг ба 2023 оны I улиралд 513 эмнэлгийн эрүүл мэндийн ажилтанд 254,541,184 төгрөг, II улиралд 504 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 273,498,056 төгрөг III улиралд 507 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 267,966,658 төгрөг Нийт 796,005,898 төгрөг олгогдсон. (Эмнэлгийн ерөнхий захирлын 2023 оны А/41, А/70, А/105 тушаалууд) Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх журмыг байгууллагын албан ёсны сайтад ил тод нээлттэйгээр байршуулсан. https://ssch.gov.mn/documents/azhlyn-bajrny-talaarh-medeelel/mn?sort=date&dir=desc&p=25	100%
Хэсгийн дундаж хувь 91,6%			
ГУРАВ. ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ			
3.1	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	2022 онд төсвий гүйцэтгэл 32.8 тэрбум 2023 онд батлагдсан төсөв 44.5 тэрбум 2024 онд төсвийн санал 54 тэрбум	92%
3.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт, Хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг шилэн дансанд байршуулж байна.	100%

3.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	2022 оны Санхүүгийн аудитаар Хязгаарлалттай дүгнэлт авсан.	100%
3.4	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	Төлбөртэй тусламж үйлчилгээний төлбөрийн хэмжээг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн ерөнхий захирлын тушаалын дагуу төлбөрийг төвлөрүүлж байна.	100%
3.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг шилэн дансанд байршуулж байна.	100%
3.6	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг шилэн дансанд байршуулж байна.	100%
3.7	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт шилэн дансанд байршуулж байна.	100%
3.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр байхгүй.	100%
3.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу шилэн дансны мэдээллийг шинэчилсэн. Шилэн дансанд 141 мэдээлэл оруулахаас 132 хцгацаанд нь оруулж, 9 мэдээлэл хугацаа хэтэрсэн байна.	93.6%
3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендер оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендер	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендер оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендер оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн	100%

	шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	үндэслэл, шалтгааныг тухай бүр tender.gov.mn цахим систем болон шилэн дансанд мэдээллэсэн.	
3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийн дагуу алдаа дутагдлыг арилгуулж жилийн эцсийн аудитын шалгалтад бэлдэж байна.	100%
3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар тухай бүр утсаар болон биечлэн мэдээлэл өгсөн.	100%
3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүнг шилэн дансанд байршуулж байна.	100%
3.14	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан тухай бүр хийгдэж байгаа.	100%
3.15	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг хязгаарласан этгээдийн жагсаалт	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг хязгаарласан этгээдийн жагсаалтад шинээр аанб бүртгэгдээгүй.	100%
Хэсгийн дундаж хувь 99,04%			
ДӨРӨВ. ҮЗҮҮЛЖ БАЙГАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ			
4.1	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээллийг нийтэд ил тод байршуулсан.	100%

	үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл		
Хэсгийн дундаж хувь 100%			
ТАВ.БУСАД МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ			
5.1	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал	Эрүүл мэндийн ажилтнуудад Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг танилцуулах, төрийн албан хаагчдаас санал авах уулзалтыг 2023 оны 05 дугаар сарын 15-нд Соёлын төв өргөөнд 09 цагаас нэгдсэн журмаар зохион байгуулан, тус уулзалтад УХТЭ-ээс нийт 50 эмч, эмнэлгийн ажилчид хамрагдан хэлэлцүүлэгт оролцсон. Түүнчлэн цахим санал авалтад оролцсон. ЭМЯ-аас ирүүлсэн санал авах албан бичигт цаг тухайд нь санал хүргүүлж ажилласан.	100%
5.2	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт	<ul style="list-style-type: none"> • Дүрс оношилгооны төвийн зөвлөх эмч Б.Эрдэнэбулган Монгол Улсын Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн №14296 дугаар бүхий гэрчилгээг “Хөхний хэт авиан оношилгоо” номын бүтээлээр оюуны өмчийн эрх авсан. • Нүд судлалын тасгийн эрхлэгч Д.Батжаргал Монгол Улсын Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн №15155 дугаар бүхий гэрчилгээг “Монгол улсад эрүүл мэндийн аялал жуулчлал эрхлэх гарын авлага (нүдний тусламж үйлчилгээ)”, №15154 дугаар бүхий гэрчилгээг “Нүд харааны эрүүл мэндийн явуулын эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхлэх төслийн гарын авлага” зэрэг бүтээлүүдээр оюуны өмчийн эрх авсан. • Цөмийн оношилгоо эмчилгээний төв нь Монгол Улсын Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн №0023243 “[18F] Натрийн фторид радио идэвхт эм”-ийг оюуны өмчийн эрхтэйгээр үйлдвэрлэж байна. • Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасгийн эмч Б.Нямжав нар нь Монгол Улсын Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн №14953 “Чихрийн шижин хэвшинж 2-той хүмүүст ABCC8 генийн RS1799854, RS1801261 полиморфизмыг бодисийн солилцооны зарим үзүүлэлтүүдтэй холбон судалсан нь” бүтээлээр оюуны өмчийн эрх авсан. 	100%

		<ul style="list-style-type: none"> • Бөөр дотоод шүүрэл судлалын тасгийн эрхлэгч С.Байгалмаа, эмч Б.Жанибек, эмч Э.Нарныгэрэл нар нь Монгол Улсын Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн №14422 “Бөөрний түүдгэнцэрийн өвчтэй хүмүүст бөөрний эдийн шинжилгээг дүгнэн, ANTIPLA2R эсрэг биеийг мембраноз нефропатийн оношилгоонд нэвтрүүлсэн байдлыг судлах” бүтээлээр оюуны өмчийн эрх авсан. • Зүрх судас судлалын тасгийн Шигдээсийн нэгжийн эмч Л.Эрдэнэхүү, эмч Д.Амарзул нар нь Монгол Улсын Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн №14940 “УХТЭ-т Пейсмекер суулгах эмчилгээ эхлүүлсэн туршлага” бүтээлээр оюуны өмчийн эрх авсан. 	
5.3	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл	<ul style="list-style-type: none"> • Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь НЗДаргын 2022.01.11-ний өдрийн А/15 тоот захирамжийн дагуу Баянзүрх дүүргийн 20-р хороонд нэгж талбарын 1333018412 дугаар бүхий 35906 м.кв газрыг рашаан сувиллын зориулалтаар 40 жилийн хугацаатай эзэмших эрхийн улсын бүртгэлийн Э-2204022178 дугаар бүртгүүлж, №00000344477 тоот цахим гэрчилгээ авсан болно. Газрыг 2018.12.31-нээр 1,504,925,260.00 төгрөгөөр санхүүгийн бүртгэлд бүртгэсэн болно. 	100%
5.4	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл	<ul style="list-style-type: none"> • 2023 онд ТӨБЗГазар болон УХТЭмнэлгийн хамтран түрээсийн 12 байгууллагатай нийт 320,924,000.00 төгрөгийн гэрээ байгуулж, ТӨБЗГазарт түрээсийн төлбөрийн 40 хувь болох 128,369,600.00 төгрөгийн орлогыг төвлөрүүлэх, байгууллагын үйл ажиллагааны орлогод 60 хувь буюу 192,554,400.00 төгрөг төвлөрүүлэхээр ажиллаж байна. 	90%
5.5	Хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавар, тэдгээрийг арилгах арга хэмжээг тогтоосон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээлэл, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл	Боловсрол шинжлэх ухааны яамны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газраас Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч нарын баг 2023 оны 06 дугаар сарын 08, 09, 12-ны өдрүүдэд Цөмийн оношилгоо, эмчилгээний төвд хяналт, шалгалт хийсэн. Хяналт, шалгалтын явцад цацрагийн хэмжилтүүд хийгдсэн бөгөөд зөрчил илрээгүй.	100%

5.6	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл	<p>1. Боловсрол шинжлэх ухааны яамны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газраас Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч нарын баг 2023 оны 06 дугаар сарын 08, 09, 12-ны өдрүүдэд Цөмийн оношилгоо, эмчилгээний төвд хяналт, шалгалт хийсэн. Хяналт, шалгалтын явцад цацрагийн хэмжилтүүд хийгдсэн бөгөөд зөрчил илрээгүй.</p> <p>2023 оны 11-р сарын 20-ны өдөр 23100608030100815 дугаартай “Цацраг идэвхт эм үйлдвэрлэх, ашиглах, хадгалах, худалдах зөвшөөрлийг” МХЕГ-аас олгосон.</p> <p>ЦОЭТ-д дараах хууль, дүрэм, журмыг мөрдөн ажилладаг:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол улсын 2009 оны “Цөмийн энергийн тухай” хууль - Цөмийн энергийн комиссын 2015 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт “Цацрагийн аюулгүйн норм” - Цөмийн энергийн комиссын 2016 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралт “Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм” - Монгол улсын 2017 оны “Хог хаягдлын тухай” хууль - ЭМС-ын 2017 оны “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах заавар” 505 тоот тушаал - Цөмийн энергийн комиссоос гаргасан “Эрүүл мэнд, аж үйлдвэр, хүнс, хөдөө аж ахуй, боловсрол, шинжлэх ухааны салбарт цацраг идэвхт материалын хэрэглээнээс үүсэх цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны зөвлөмж” - УХТЭ-ийн “Аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх” журам - IAEA, Management of radioactive waste from the use of radionuclides in medicine /IAEA-TECDOC-1183/ <p>2. Радиологийн тасагт рентген шинжилгээ хийлгэж байгаа үйлчлүүлэгчдэд зураг авах хэсгээс бусад биеийн хэсгүүдэд туяанаас хамгаалах зориулалтын хэрэгслүүдийг ашиглаж байна. Рентген ба Компьютер томографийн шинжилгээ хийх үед бусад үйлчлүүлэгч өрөөний хаалга</p>	100%
-----	---	---	------

		<p>онгойлгож цацрагт өртөх эрсдлээс сэргийлж хаалганы соронзон цоож, анхааруулах улаан гэрлийг ашиглаж байна.</p> <p>3. Ариутгал халдваргүйтгэлийн тасагт халдвартай хог хаягдал, хурц үзүүртэй хог хаягдал нь ЭМС-ын А/505 тоот тушаал, УХТЭ-ийн “Аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх” журмын дагуу хог хаягдлын ажилтан хамгаалах хувцас хэрэгсэл бүрэн өмсөж зориулалтын тэмдэг тэмдэглэгээ бүхий тагтай тэнгэрцэрт халдвартай хог хаягдал хүлээн авч халдвартай хог хаягдал түр хадгалах байранд зориулалтын тагтаа саванд байршуулан ЭЛЕМЕНТ ХХК-тай гэрээнд заасан хуваарийн дагуу хүлээлгэн өгнө. 2023 оны 11 дүгээр сарын 12 өдөр Unicef НҮБ-ийн Хүүхдийн сан, NEWSTER компанитай хамтран Итали технологийн халдвартай хог хаягдал устгах тоног төхөөрөмжийг байршуулсан. Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааварчилгааны 4 удаагийн сургалтанд 16 ажилтан хамрагдсан байна.</p> <p>4. ХСҮТ-с боловсруулан гаргасан ЭМЯ-ны 2021 оны 9 сард баталсан “Хорт хавдрын хими эмчилгээний удирдамж”-ыг баримталж хими, бай эмчилгээний тусламж үйлчилгээг үзүүлж байна.</p>	
5.7	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт	2023 онд Хүүхдийн эмнэлэг, Үндэсний оношлогоо эмчилгээний төвийн барилгын улсын комиссын дүгнэлт гарсан тул үндсэн хөрөнгийн бүртгэлд авах албан бичгийг ЭМЯ-аар дамжуулан 2023.4.21 №5/387, 2023.11.24 №6/954 тоот албан бичгүүдийг ТӨБЗГазарт явуулсан.	85%
5.8	Шүүн таслах ажиллагааны дүн мэдээ	Шүүн таслах ажиллагаа байхгүй.	100%
5.9	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу маргаан хянан шийдвэрлэсэн ажиллагааны дүн мэдээ	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийн тохиолдол байхгүй.	100%
5.10	Хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл	ТӨБЗГазартай байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх” гэрээг 83 үнэлгээтэй дүгнүүлэн, 2023.10.23-нд шинээр “Төрийн өмчийг эзэмшүүлэх” гэрээ хийв.	83%
5.11	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр,	<ul style="list-style-type: none"> • 2023 онд Төрийн сангийн санхүүжилтээр нийт 18 сувилагч төрөлжсөн мэргэшлийн сургалтанд хамрагдсан. Үүнд - Эрчимт эмчилгээний сувилахуй-4 	100%

	мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт	<ul style="list-style-type: none"> - Мэс заслын сувилахуй-14 • Эрүүл мэндийн яам, БНСУ-ын олон улсын эрүүл мэндийн сангийн Dr.Lee Jong-Wook-ын тэтгэлэгт сургалтын хүрээнд БНСУ-ын Сөүл хотын Сөүлийн үндэсний их сургуулийн Бунданг эмнэлэгт уушги судлалын чиглэлээр 1 эмч сургалтанд хамрагдсан • Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын “Гадаад сургалтын төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/38 дугаар тушаалаар БНСУ-ын Улсан хотын их сургуулийн эмнэлэгт Судсан дотуурх хавхлаг солих мэс заслын мэргэжлээр сургалтад 2 эмч, 1 сувилагч, 1 рентген техникч, гар сарвууны мэс заслын чиглэлээр 1 эмч хамрагдсан. • Эрүүл мэндийн хөгжлийн төв болон Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын санхүүжилтээр “Монгол улсын эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төслийн хүрээнд 1 ахлах сувилагч, 1 сувилахуйн арга зүйч Япон улсад сургалтанд хамрагдсан. • Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Тайваний Linkou хотын Chang Gung Memorial Hospital эмнэлэгт Мэдрэлийн мэс заслын үеийн мэдээгүйжүүлэг чиглэлээр 1 эмч, зүрхний мэс заслын үеийн мэдээгүйжүүлэг чиглэлээр 1 эмч сургалтанд тус тус хамрагдсан. 	
5.12	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан	Авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж, тайланг Эрүүл мэндийн яаманд 2023 оны 06 дугаар сард, 2023 оны 12 дугаар сард тус тус хүргүүлсэн.	100%
5.13	Албан тушаалтны Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар	“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн давхардсан тоогоор 120 мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар авсан.	100%
5.14	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн	Нийтийн албанд шинээр, хавсран болон түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр нь дэвшсэн 11 этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг (ХАСУМ) Авилгатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулж албан тушаалд томилсон.	100%

	ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт		
5.15	Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэл	Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу нийт 98 эрүүл мэндийн ажилтан ажлаас чөлөөлөгдсөн.	100%
5.16	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл	Байхгүй	100%
Хэсгийн дундаж хувь 97,4%			
Хэрэгжилтийн дундаж хувь 96,6%			

ТАЙЛАН БИЧСЭН: ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБА
 САНХҮҮ, БҮРТГЭЛИЙН АЛБА
 ЭДИЙН ЗАСАГ, ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА